

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 29 өдөр


Дугаар: A/108

Улаанбаатар хот

**Журам шинэчлэн батлах
тухай**

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.3.1, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.3.2, Гүйцэтгэх захирлын 2022 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод (журам) хэм хэмжээ”-ний 2.8.5, 2.8.17, 2.11-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Малын индексжүүлсэн даатгалын борлуулалтын журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. “Малын индексжүүлсэн даатгалын борлуулалтын журам”-ын хэрэгжилтийг хангаж, холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандaa мөрдөж ажиллах, журмыг малын индексжүүлсэн даатгалд оролцогч даатгалын компаниуд, даатгалын зуучлагч болон даатгалын төлөөлөгч нарт хүргүүлж танилцуулах арга хэмжээ авч ажиллахыг Андеррайтингийн газар (Б.Батбаяр)-т тус тус үүрэг болгосугай.
3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн “Малын индексжүүлсэн даатгалын борлуулалтын журмыг батлах тухай” А/39, 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн “Журам батлах тухай” А/25 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
4. Энэхүү тушаалыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.



Б.ЖАВХЛАНТ

МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН
БОРЛУУЛАЛТЫН ЖУРАМ

Mongolian Re

УЛААНБААТАР ХОТ
1119282186 ✆ 5885612

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Үндэсний давхар даатгал ХК (цаашид “Давхар даатгагч” гэх) болон Малын индексжүүлсэн даатгал (цаашид “МИД” гэх)-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, Давхар даатгагчтай МИД-ыг борлуулах гэрээ байгуулсан даатгалын компаниуд (цаашид “Даатгагч” гэх), зуучлагч, тэдгээрийн орон нутгийн салбар нэгж болон даатгалын төлөөлөгч МИД-ын борлуулалтын үйл ажиллагаа явуулах, борлуулалтын бүртгэл хөтлөх, түүнд хяналт тавихтай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Энэ журам нь Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль (цаашид “Хууль” гэх) болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

1.3. Энэ журмыг Давхар даатгагч, Даатгагч, зуучлагч болон даатгалын төлөөлөгч мөрдөж ажиллана.

1.4. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.4.1. “МИД” гэж даатгалын тохиолдол бий болоход Хууль болон гэрээнд заасны дагуу нөхөн төлбөр төлөх даатгалын стандарт бүтээгдэхүүнийг;

1.4.2. “Зуучлагч” гэж даатгалын зуучлалын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй, Даатгагчтай МИД-ын зуучлалаар хамтран ажиллах гэрээ байгуулсан зуучлагч банк болон бусад даатгалын зуучлагчдыг;

1.4.3. “МИД-ын баталгаа” (цаашид “баталгаа” гэх) гэж даатгуулагчийн ямар төрлийн малыг хэдэн төгрөгийн үнэлгээгээр сонгож, нийт хэдэн төгрөгийн даатгалын хураамж төлснийг баталгаажуулсан баримт бичгийг;

1.4.4. “МИД-ын гэрээ” (цаашид “гэрээ” гэх) гэж даатгуулагч баталгаанд бичигдсэн хураамж төлөх, Даатгагч нь баталгаанд заасан тухайн малын сонгосон үнэлгээгээр даатгаж, даатгалын тохиолдол бий болоход даатгуулагчид нөхөн төлбөр төлөх болон Даатгагч, даатгуулагчийн хооронд үүсэх МИД-тай холбоотой бусад харилцааг зохицуулсан баримт бичгийг;

1.4.5. “Борлуулалтын улирал” гэж Давхар даатгагч болон Даатгагчийн хооронд байгуулсан “Малын индексжүүлсэн даатгалын алдагдал зогсоо давхар даатгалын гэрээ”-нд тодорхойлж заасан хугацааг.

Хоёр. МИД-ын борлуулалтын үйл ажиллагаа, бүртгэл

2.1. Даатгагч нь тусгай зөвшөөрөл бүхий даатгалын төлөөлөгч, зуучлагчаар дамжуулан МИД-ын борлуулалтын хугацаанд Давхар даатгагчийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан гэрээний загварын дагуу МИД-ын бүтээгдэхүүнийг худалдан борлуулна.

2.2. Баталгаа нь энэ журмын хавсралтаар батлагдсан загварын дагуу 2 хувь үйлдэгдэх ба баталгаанд баталгааны дугаар, Даатгагчийн нэрийг заавал бичнэ.

2.3. МИД-ын бүтээгдэхүүнийг борлуулахдаа даатгуулагчийн “А” дансны мэдээлэлд үндэслэнэ.

2.4. Зуучлагч нь даатгуулагчийн малын төрөл тус бүрт даатгалын хураамжийг 150,000, 200,000, 300,000, 500,000, 800,000 төгрөгийн аль нэгээр, эсхүл малын үнэлгээнээс шалтгаалан төлж болох доод хураамж болон дээд хураамжийг тооцоолж даатгуулагчтай гэрээ байгуулна.

(Энэ хэсэгт Гүйцэтгэх захирлын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/02 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан)

2.5. Даатгагч, зуучлагч банк нь гэрээ, баталгааг алдаагүй, дэс дараалсан дугаарлалттайгаар хэвлүүлж бүртгэл хөтөлнө. Хэвлэлтийн алдаанаас гарсан хохирлыг буруутай этгээд хариуцна.

2.6. Даатгагч, зуучлагч нь тусгайлан боловсруулж хөгжүүлсэн программ хангамж ашиглан зориулалтын төхөөрөмж, гар утасны программаар МИД-ын бүтээгдэхүүнийг борлуулж байгаа тохиолдолд тухайн төхөөрөмж, программ хангамжийн хэвийн үйл ажиллагааг хангана.

2.7. Батлагдсан гэрээ, баталгааны загварт тусгасан зохицуулалтыг гэрээний аль нэг тал өөрчлөхийг хориглоно.

2.8. Баталгааг Даатгагчид хоорондоо болон тусгай зөвшөөрөлгүй этгээдэд шилжүүлэн ашиглуулахыг хориглоно.

2.9. Даатгалын төлөөлөгч, зуучлагч нь гэрээ байгуулахаас өмнө гэрээний зүйл, заалт болон МИД-ын талаар даатгуулагчид дэлгэрэнгүй тайлбарлаж ойлгуулах үүрэгтэй бөгөөд даатгуулагчийг бүрэн мэдээлэлтэй болсны дараа гэрээ байгуулна.

2.10. Баталгаанд даатгуулагчийн талаарх мэдээлэл, харьяалагдах аймаг, сум болон даатгалын тооцооллыг бичихдээ цэвэр гаргацтай, үнэн зөв, бүрэн гүйцэд бөглөнө.

2.11. Даатгалын төлөөлөгч, зуучлагч нь даатгуулагчаас хураамж авч, гэрээ болон баталгаанд хоёр тал гарын үсэг зурснаар уг гэрээ, баталгааг хүчинтэй гэж үзэх бөгөөд дараах этгээдэд хүргүүлнэ:

2.11.1. Нэгдүгээр эх хувийг Даатгагч, зуучлагчид;

2.11.2. Хоёрдугаар хувийг даатгуулагчид.

2.12. Даатгагч, зуучлагч нь гэрээ байгуулахдаа даатгуулагчаас тухайн жилд МИД-д хамрагдсан эсэхийг сайтар нягтлах ба нэг төрлийн малыг давхардуулан гэрээ байгуулахыг хориглоно.

2.13. Даатгагч, зуучлагч нь нэг малчны аль нэг төрөл малыг давхардуулан даатгасан тохиолдолд Даатгагч хуанлийн 7 хоногт багтаан МИД-ын программд бүртгэсэн тохиолдолд уг гэрээг хүчинтэйд тооцож, зуучлагчийн байгуулсан гэрээг хүчингүйд тооцно.

2.14. Энэ журмын 2.13-т заасан хуанлийн 7 хоногийн хугацааг хэтрүүлсэн тохиолдолд Даатгагч, зуучлагчийн аль түрүүлж МИД-ын программд бүртгэсэн гэрээг хүчинтэйд тооцож, сүүлд бүртгэсэн гэрээг хүчингүйд тооцно.

2.15. Хүчингүйд тооцсон гэрээг МИД-ын программын "Хүчингүй болсон төлөв"-т бүртгэн даатгалын хураамжийг ажлын 3 өдрийн дотор даатгуулагчид буцаан олгоно.

2.16. Даатгагч, зуучлагч нь энэ журмын 2.13, 2.14-т заасны дагуу гэрээ хүчингүй болсон тохиолдолд даатгуулагчийн зөвшөөрлөөр өмнө даатгаснаас өөр төрлийн малыг нь даатгаж болно.

2.17. Даатгагч, зуучлагч нь гэрээ, баталгааны бүртгэл хөтлөхдөө МИД-ын программ хангамжийн гарын авлагын зааварчилгааг дагаж мөрдөнө.

2.18. Гэрээ, баталгаанд даатгуулагчийн овог, нэр, харьяалал, регистрийн дугаар зэрэг хувийн мэдээллийг буруу бичих, буруу бүртгэх, даатгалын хураамж, үнэлгээг буруу тооцоолох зэргээс шалтгаалсан аливаа хохирлыг буруутай этгээд хариуцна.

Гурав. МИД-ын борлуулалтын үйл ажиллагааг дуусгах, үр дүнг тооцох

3.1. Даатгагчийн орон нутаг дахь салбар нь МИД-ын борлуулалтын үйл ажиллагааг аймгийн түвшинд жил бүрийн 7 дугаар сарын 31-ний өдрийн дотор дуусгах бөгөөд энэ хугацаанд багтаан борлуулалтын бүртгэлийг МИД-ын программд бүртгэх, алдаа залруулах зэрэг ажлыг хийж дуусгана.

(Энэ хэсгийг Гүйцэтгэх захирлын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн A/02 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан)

3.2. Даатгагчийн орон нутаг дахь салбар нь даатгалын төлөөлөгчидтэй баталгаа, хураамжийн орлогын тооцоог дуусгах ажлыг энэ журмын 3.1-д заасан

хугацаанд багтаан хийж дуусгана. Тооцоо нийлэхдээ МИД-ын программын бүртгэлтэй давхар тулгаж шалгасан байна.

3.3. Даатгагч, зуучлагч нь борлуулалт хийсэн гэрээ, баталгааны нэгдүгээр хувийг аймаг, sumaар нь ангилж, баталгааны дугаараар нь эрэмбэлэн Даатгагчийн төв салбартаа жил бурийн 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор хүргүүлсэн байна.

(Энэ хэсэгт Гүйцэтгэх захирлын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/02 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан)

3.4. Даатгагчийн төв салбар нь МИД-ын программын баталгааны бүртгэлийг шалгахдаа дараах мэдээллүүдийг хянан баталгаажуулсан байна:

3.4.1. Бүртгэгдсэн баталгааны тоо нь тухайн Даатгагчийн орон нутаг дахь салбарт анх олгогдсон баталгаа болон нэмэлтээр авсан баталгааны тооны нийлбэртэй тэнцүү байх шаардлагатай.

3.4.2. Баталгаа нь борлуулалт хийсэн, хүчингүй болсон, буцаан олгосон болон хаясан төлөвүүд дээр бүртгэгдсэн байна. Борлуулалтын үйл ажиллагааг дуусгахад “олгогдсон төлөв”-тэй баталгаа байж болохгүй.

3.5. Зуучлагч нь МИД-ын программын борлуулалтын бүртгэлийг шалгахдаа дараах мэдээллийг хянан баталгаажуулсан байна:

3.5.1. Даатгагч, зуучлагч нь борлуулалтын тоо, даатгалын хураамж, даатгуулагчийн харьялал, холбогдох мэдээллийг нэг бүрчлэн шалгаж, алдаатай мэдээллүүдийг даатгуулагчаас асууж, баталгаажуулсны үндсэн дээр залруулах арга хэмжээ авсан байна.

3.5.2. Зуучлагч нь МИД-ын программын борлуулалтын жагсаалтаас борлуулсан бүртгэлийг нягталж, “давхардсан” төлөвт гэрээ бүртгэгдсэн тохиолдолд тооцоо нийлэх үед засаж, залруулсан байна.

Дөрөв. Даатгагч, зуучлагчийн эрх, үүрэг

4.1. Даатгагч нь өөрийн салбар нэгжтэй аймагт даатгалын төлөөлөгчөөр болон зуучлагчаар дамжуулан МИД-ыг борлуулна.

4.2. МИД-ын борлуулалтын мэдээллийг МИД-ын программд харуулах, тайлagnah, Давхар даатгагчийг борлуулалтын мэдээллийг хянах боломжоор хангах үүрэгтэй.

4.3. Даатгуулагчийн мэдээлэл, даатгалын тооцооллыг алдаатай бүртгэнээс гарсан аливаа хохирлыг гэрээ байгуулсан Даатгагч, эсхүл зуучлагч хариуцна.

4.4. Даатгуулагчтай гэрээ байгуулсан, баталгаа үйлдсэн өдрөөс хойш хуанлийн 7 хоногийн дотор энэ журмаар тогтоосон шаардлагатай мэдээллийг МИД-ын программд бүртгэх үүрэгтэй.

4.5. Даатгуулагчид баталгааг хэвлэж өгөх үүрэгтэй. Гэрээг хэвлэж өгөөгүй тохиолдолд цахим хаягаар хүлээн авах боломжийг олгоно.

4.6. Тухайн жилийн МИД-ын борлуулалтын улирал дууссаны дараа энэ журмын 3.1-д заасан бүртгэлд үндэслэн Даатгагч нь тухайн аймагт даатгалын төлөөлөгчөөр борлуулсан МИД-ын борлуулалтын дүнгээр хувь тэнцүүлэн зуучлагч банкаар борлуулсан багцыг хуваан авна.

(Энэ хэсгийг Гүйцэтгэх захирлын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/02 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан)

4.7. МИД-ын борлуулалтын улирал дууссаны дараа борлуулалтын үр дүнг эцэслэн баталснаас хойш гэрээ, баталгааг цуцлах, хураамж, үнэлгээ болон бусад борлуулалтын мэдээллийг өөрчлөхийг хориглох бөгөөд өөрчилснөөс учирсан хохирлыг буруутай этгээд хариуцна.

4.8. Энэ журмын 3.1-д заасан хугацаанаас хойш борлуулалтын үр дүнг баталгаажуулах хооронд Даатгагч аливаа баталгааг хүчингүй болгосон, МИД-ын программаас борлуулалтын бүртгэлийг устгасан тохиолдолд устгасан, хүчингүй болгосон борлуулалтын дүнг энэ журмын 4.6-д заасны дагуу хийсэн тооцооллоос хувь тэнцүүлэн хасаж, борлуулалтын дүнг дахин тооцоолно.

(Энэ хэсгийг Гүйцэтгэх захирлын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/02 дугаар тушаалаар нэмсэн)

Тав. Давхар даатгагчийн эрх, үүрэг

5.1. Давхар даатгагч нь МИД-ын программ хангамжийг боловсруулж, хэвийн ажиллагааг хангах, программд оруулсан бүртгэлийг хянах үүрэгтэй.

5.2. Гэрээний оролцогч талуудаас гэрээ, баталгаатай холбоотой ирүүлсэн аливаа хүсэлт, гомдол, саналыг тухай бүр шийдвэрлэх үүрэгтэй.

5.3. Давхар даатгагч улирал бүрийн эцэст санхүүгийн тайлан бэлтгэх зорилгоор энэ журмын 4.6-д заасан зуучлагчийн багцаас Даатгагчдад хуваарилах хураамжийн дүн, даатгалын үнэлгээг тооцоолж, Даатгагч болон зуучлагч банканд хүргүүлнэ.

5.4. Зуучлагч банкны МИД-ын хураамж нь тухайн жилийн МИД-ын борлуулалтын улирал дуустал Давхар даатгагчийн дансанд байршил ба борлуулалтын үр дүнг эцэслэн баталсны дараа зуучлалын шимтгэл хасагдсан дүнгээр Даатгагчийн дансанд шилжүүлнэ.

Зургаа. Бусад зүйл

6.1. Давхар даатгагч энэ журмын хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн журмыг шинэчилнэ.

6.2. Энэ журмаар зохицуулсан харилцааг зэрчсөн тухай мэдээлэл, гомдлыг Давхар даатгагчид бичгээр гаргаж, холбогдох баримт бичгийн хамт хүргүүлэх бөгөөд ирсэн гомдлыг ажлын 10 өдрийн дотор шийдвэрлэж, хариуг гомдол, мэдээлэл гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

6.3. Давхар даатгагч энэ журам болон бусад холбогдох хууль тогтоомжийг зэрчсөн, ёс зүйгүй ажилласан Даатгагчийн ажилтан, даатгалын төлөөлөгч болон зуучлагчид холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага тооцуулах саналыг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх эрхтэй.

Долоо. Журмын хавсралт

7.1. Хавсралт-1 “Баталгаа”-ны загвар

7.2. Хавсралт-2 “Пос болон киоск машинаас гарах баталгаа”-ны загвар

---оОо---

Mongolian Re

УЛААНБААТАР ХОТ
1119282186 ± 5885612

Баталгааны дугаар

МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН БАТАЛГАА

МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН БАТАЛГАА

Даатгалын компанийн нэр:

Даатгалын төлөөлөгчийн нэр:

Аймгийн нэр:

Сумын нэр:

Багийн дугаар:

Даатгуулагчийн овог:

Даатгуулагчийн эзгийн нэр:

Даатгуулагчийн нэр:

Даатгуулагчийн яс үндэс:

Регистр №:

Даатгуулагчийн утасны дугаар:

Даатгуулагчийн банкны нэр:

Дансны дугаар:

Энэхүү даатгалын баталгааны ягаан өнгийн
(2-р) хувийг малчин өөртөө үлдээнэ.

Даатгалын төлөөлөгч цагаан өнгийн (1-р) хувь,
шар өнгийн (3-р) хувийг өөрийн харьялагдах
даатгалын компанид хүргүүлэх үүрэгтэй.

Малын Индексжүүлсэн Даатгал (МИД)

Малын индексжүүлсэн даатгалын нөхөн төлбөрийг даатгуулагчийн өмчлөлд буй малын хорогдлын хэмжээг үл харгалzan, тухайн сумын малын хорогдлын статистикийн албан ёсны мэдээ буюу дунд үндэслэнэ. Тухайн сумын малын хорогдол босго үзүүлэлтээс давсан тохиолдолд нөхөн төлбөр олгоно. Малын төрөл тус бүрийн хорогдлыг МИД-ын гэрээнд заасны дагуу тооцно. Энэхүү баталгаа нь МИД-ын гэрээний салшгүй хөсөг болно.

№	Малын төрөл	Хонь	Ямаа	Үхэр ба сарлаг	Адуу	Тэмээ
1	Хураамжийн хувь					
2	Даатгуулагчийн малын тоо					
3	Нэгж малын үнэ, төгрөгөөр					
4	Даатгалдах дээд хязгаар, малын үнэлгээний 100% (2 мөр * 3 мөр), төгрөгөөр					
5	Даатгуулагчийн даатгуулахаар сонгож буй малын үнэлгээ, төгрөгөөр					
6	Даатгалын хураамж, тогроогоор (1 мөр * 5 мөр / 100)					
7	Даатгалын компанийн хөнгөлэлт					
8	Даатгуулагчаас төлөх нийт хураамж (6 мөр - 7 мөр), төгрөгөөр					

* Тухайн сумын малын төрөл тус бүрийн тоо толгой 5000-аас бага байх тохиолдолд хонин сүргийн хорогдлоор төлөвлүүлэн нөхөн төлбөрийг олгоно.

Нийт дун (төг)

Даатгуулагч би энэхүү Малын индексжүүлсэн даатгал нь энэ оны жилийн эцсийн мал тооллогоо дараа оны хагас жилийн мал тооллогоо хугацаан дахь эрсдэлний сумын малын хорогдлын хувь хэмжээнд үндэслэн даатгаж нөхөн төлбөр олгохыг, мөн сумын малын хорогдлын түвшин босго үзүүлэлтээс хэтрээгүй тохиолдолд нөхөн төлбөр авахгүй болохыг хүлээн зөвшөөрч байна. Би өөрийн өмчлөлийн малын тоог үнэн зөвөөр мэдүүлсэн болохыг баталж байна.

Даатгуулагчийн гарын үсэг:ОНсар.....өдөр

Даатгач би даатгалын ач холбогдлыг малчад үнэн зөвөөр мэргэжлийн түвшинд ойлгуулах үүрэгтэй. Би даатгуулагчаас авсан хураамжийн орлогыг компанийн дансанд тушааж, даатгалын баталгааны цагаан, шар өнгийн (1,3-р) хувь, хураамжийн баримтыг тус бур өөрийн даатгалын компанийд борлуулалт хийнээс хойш ажлын 10 хоногийн дотор буюу борлуулалтын улирлын хугацаа дууставар болох 6-р сарын 30-ны өдрөөс хойш 7 хоногийн дотор хүлээлгэн өгөх үүрэг хүлээж байна.

Даатгалын төлөөлөгчийн гарын үсэг:ОНсар.....өдөр /тамга/

Хянан, баталгаажуулсан Даатгалын
компанийн салбарын захирал:ОНсар.....өдөр

Малын индексжуулсан даатгалын
борлуулалтын журмын ХАВСРАЛТ-2

МАЛЫН ИНДЕКСЖУУЛСЭН ДААТГАЛЫН
БАТАЛГАА



МАЛЫН
ИНДЕКСЖУУЛСЭН
ДААТГААЛ

Mongolian Re

УЛААНБААТАР ХОТ
1119282186 ёш 5885612

Гэрээн дугаар: ...
Даатгач: ...
ДААТГУУЛАГЧ
Овог: ...
Нэр: ...
Регистрийн дугаар: ...
Гэрийн хаяг: ...
Утасны дугаар: ...
Банкны нар: ...
Дансны дугаар: ...

Хонины даатгал
Хураамжийн хувь: ...
Малын тоо: ...
Ямааны даатгал
Хураамжийн хувь: ...
Малын тоо: ...
Үзүүлэлийн даатгал
Хураамжийн хувь: ...
Малын тоо: ...
Адууны даатгал
Хураамжийн хувь: ...
Малын тоо: ...
Тэмээний даатгал
Хураамжийн хувь: ...
Малын тоо: ...
Даатгуулсан үнэлгээ:
Даатгалын хураамж:
Даатгуулагч толх:

Даатгалын хураамж: ...

Гэрээний байгуулсан: ...

Онцлог:



Асимон Брокерс ХХК нийчүү гурвал цахилгаар
тухайнд байгуулсан болно. Та барилт уялж
чөгийн төслийн төмөнгийн тус компанийн
хялбар хандав уу.

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот-14210, Сүүбаяар дүүрэг 1-
р хороо, Оюутанын гудамж-3, Аюут Тэээр, 12 давхар
Утас: 70116240

НОАТ-ын баримт:

Сугалаз:
Үнийн дүн:



ДДТД 000006235972002220801412624326309

Өнөөгүй баримт нь НОАТ-ын огуулж датчуу
72 цагт багтаагахыг ишигдэж уу

TermID: Монгол
Approval: RRN
DATE/TIME: AMOUNT/MNT/



Гэрээ Системс ХХК
Утас: 77773773 Веб: www.garee.mn

БАРИМТЫН БАР КОД:



103022080114372509138

ҮЙДСОННЯА ДАДХАР ХК
Утасны дугаар: 9607-0770 7577-0202